



МОНГОЛ УЛСЫН ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ХУРАЛДААНЫ 2017 ОНЫ ТАЙЛАН

Монгол Улсын Харилцаа Холбооны Зохицуулах Хороо (цаашид ХХЗХ гэх)-ноос тайлангийн хугацаанд байгууллагын үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаа, ХХЗХ-ны Дарга /буюу Төсвийн шууд захирагч/ болон Монгол Улсын Ерөнхий сайд /буюу Төсвийн ерөнхийлөн захирагч/ нарын хооронд 2017 онд байгуулсан бүтээгдэхүүн нийлүүлэх үр дүнгийн гэрээний зорилт, арга хэмжээ, төлөвлөгөөт ажил болон удирдлагаас өгсөн чиглэл, үүрэг даалгавар, бусад ажлын хүрээнд арга хэмжээ, төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлсэн болно.

ХХЗХ-ны дүрэм, Дарга, Хорооны хуралдаанаас өгсөн үүрэг даалгавар, удирдамж чиглэл, хуралдааны дэгийн дагуу 2017 оны бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилгоор Хорооны ээлжит хуралдааныг 2017 онд нийтдээ 11 удаа, ээлжит бус хуралдааныг 1 удаа тус тус зохион байгуулж, байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөт болон цаг үеийн нийтдээ 82 асуудлуудыг хэлэлцэн хорооны тогтоол, хуралдааны тэмдэглэл гарган тус тус шийдвэрлэсэн болно.

Мэдээлэл, харилцаа холбооны салбар нь 2017 оныг эрх зүйн шинэчлэлтийн жил болгож зарласантай холбогдуулан.

Хууль тогтоомжийн тухай:

- ❖ Монгол Улсын хуулийн дагуу Харилцаа холбооны тухай, Радио долгионы тухай, Шуудангийн тухай Монгол Улсын хуульд урьдчилсан тандан судалгаа, нөлөөллийн дүн шинжилгээг ХХМТГ, ХХЗХ-ноос зохион байгуулж гүйцэтгэв.
- ❖ Мэдээлэл, харилцаа холбооны салбарын хууль эрх зүйн орчинг шинэ үүссэн нөхцөл байдал, техник технологийн хурдацтай хөгжилд нийцүүлэн боловсронгуй болгох, хуулийн хэрэгцээ шаардлагыг урьдчилан тандан судлах ажлын хүрээнд ХХМТГ, ХХЗХ-ны Даргын хамтарсан тушаалаар Харилцаа холбооны тухай, Радио долгионы тухай, Шуудангийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хэрэгцээ шаардлагыг тандан судалгааны ажлын хэсгийг төр, хувийн хэвшил, экспертийн төлөөллийг оролцуулан байгуулж, судалгааны үр дүнг Даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, цаашид баримтлан ажиллах удирдамж, чиглэл өглөө. Эдгээр хууль эрхзүйн актууд нь манай салбарын хүрээнд зах зээлд тоглогч талуудын хууль, эрх зүйн харилцааг хангаж байгаа хэдий ч харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын үсрэнгүй хөгжил, тэлэлтээс хамаарч нарийвчилсан зохицуулалт хийх, салбар хоорондын уялдааг хангах, салбарын эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, түүнийг хамгаалах, хязгаарлагдмал нөөц болох Радио давтамж болон Дугаарлалтыг оновчтойгоор ашиглах, зохицуулалт хийх, Сүлжээний нэгдсэн бодлого,



төлөвлөлтийг нарийвчлан зохицуулах шаардлага бидний өдөр тутмын үйл ажиллагаа, амьдралаас урган гарч ирж байна. Эдгээр хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах талаар хуулийн үзэл баримтлалыг боловсруулж, Засгийн газарт өргөн бариад байна.

- ❖ Өргөн нэвтрүүлгийн хууль эрхзүйн орчинг бий болгох, өргөн нэвтрүүлгийн контентийн зохицуулалтыг хуульчлах зайлшгүй шаардлага тулгарч байна. Түүнчлэн өргөн нэвтрүүлгийн салбарын хөгжил, бодлого, зохицуулалтад шаардлагатай зах зээлийн багтаамжийн судалгаа, телевиз үзэлтийн болон бусад нарийвчилсан судалгааг хөндлөнгийн мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж холбогдох мэдээ, тайлан гаргах, судалгааны дүнд үндэслэсэн бодлого, зохицуулалтыг орчинг бүрдүүлэхэд онцгой анхааран ажиллаж байна.
- ❖ Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.2 болон Харилцаа холбооны зохицуулах хорооны дүрмийн 3.1.2 дах хэсгийг үндэслэн “Харилцаа холбооны зохицуулах хорооны нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг Хорооны Даргын 2017 оны А/203 тоот тушаалын хавсралтаар батлан 2017 оны 10 дугаар сарын 06-ны өдрөөс мөрдөж эхлээд байна. Энэхүү баримт бичиг нь Монгол Улсын хууль, тогтоомж болон Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын стандарт, Монгол Улсын Сангийн яамны сайд, ХХЗХ-ны даргын тушаалаар баталсан журам, заавар, аргачлалын шаардлагад бүрэн нийцсэн бөгөөд тус хорооны нягтлан бодох бүртгэлийг хөтөлж, санхүүгийн тайланг бэлтгэхэд баримтлах ажлын бодлого, зарчим, горим, агуулга, удирдлага зохион байгуулалт, аргачлалыг тогтоож өгсөн чухал ач холбогдолтой бодлогын баримт бичиг юм.

Үйлчилгээ эрхлэгчдийг зах зээлд шударга, үр ашигтай өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх зорилгын хүрээнд:

- Үнэ тарифын зохицуулалтад баримтлах “Харилцаа холбооны үйлчилгээний үнэ тариф, өрсөлдөөний талаар баримтлах бодлогын чиглэл”-ийг зах зээлийн чиг хандлага, технологийн хөгжилтэй уялдуулан ХХМТГ-тай хамтарч шинэчлэн батлууллаа. Уг баримт бичиг батлагдсанаар харилцаа холбооны салбарын үнэ тариф, өрсөлдөөний чиглэлээр тулгамдаад байсан зах зээлийн зохицуулалтын баримт бичгийг шинэчлэх, үнэ тарифыг шинээр тогтоож батлах, Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэх боломжийг бүрдүүлэв.
- ❖ Харилцаа холбооны зохицуулах хорооноос Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны сонгуулийн сурталчилгаанд мониторинг хяналт хийж ажиллав. Энэ үеэр тус хороо нь Сонгуулийн тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.18-д заасан чиг үүргийн дагуу тусгай ажлын хэсэг байгуулж, радио, телевизээр нэвтрүүлсэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуулийн сурталчилгаанд 2017 оны 6 дугаар сарын 05-ны өдрөөс 7 дугаар сарын 08-ны өдрийн хооронд



- нийт 34 хоногийн хугацаанд хяналт тавьж, хэрэгжилтийг хангуулах талаар холбогдох арга хэмжээ авч ажилласан болно.
- ❖ Сонгуулийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд www.cgc.gov.mn цахим хуудсанд “Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль-2017” дэд цэс нээж, сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх, хяналт тавих үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомж, холбогдох мэдээ, мэдээлэл, зөвлөмжийг тухай бүр гаргаж, хяналтын дүн мэдээ, тайланг 7 хоногоор тухай бүр олон нийтэд мэдээлсэн. Сонгуулийн сурталчилгааны үеэр радио, телевизийн үйлчилгээ эрхлэгчдийг сурталчилгаа нэвтрүүлэхдээ Сонгуулийн тухай болон холбогдох хууль тогтоомжийг зөрчихгүй байлгах үүднээс анхааруулсан албан тоотыг 2-3 удаа хүргүүлж, хяналт мониторингийн дүнд үндэслэн анхааруулах, сануулах болон илэрсэн зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээг авч ажилласан.
 - ❖ Мэдээлэл, харилцаа холбоо, шуудангийн салбарын зохицуулалтын чиглэлээр одоо хүчин төгөлдөр мөрдөж буй зохицуулалтын баримт бичиг болох 19 журам, 25 нөхцөл шаардлага, техникийн нөхцөл, давтамжийн зохицуулалт, хуваарилалтын баримт бичгийн 44 эрх зүйн актад гэрээний үндсэн дээр дүн шинжилгээ хийлгэж, эдгээр баримт бичгүүд Захиргааны ерөнхий хуульд нийцэж байгаа эсэх талаар дүгнэлт, зөвлөмжийг зөвлөх үйлчилгээний байгууллагатай хамтран гаргаж, зохицуулалтын баримт бичгүүдийг Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэх арга хэмжээг авлаа.
 - ❖ Хүчин төгөлдөр мөрдөж байгаа журам, нөхцөл шаардлага, радио давтамжийн хуваарилалт, техникийн нөхцөл шаардлага, Ерөнхийлөгчийн сонгуультай холбоотой журам зэрэг эрхзүйн баримт бичгийг Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэх, өөрчлөлт оруулах, шинэчлэн батлах, улмаар ХЗДХЯ-ны Захиргааны хэм, хэмжээ тогтоосон шийдвэрийн улсын бүртгэлийн санд бүртгүүлэх, хорооны баталсан тогтоол шийдвэрийн талаар дүгнэлт, зөвлөмж албан ёсоор авч хамтран арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.
 - ❖ “Харилцаа холбооны зохицуулах хорооны хуралдааны дэг” шинэчлэх, “Радио давтамжийн ашиглалт, үйлчилгээний төлбөрийн хэмжээ”; “Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ”-г шинэчлэн тогтоох, “Сүлжээ хооронд харилцан холболт хийх, гэрээний ерөнхий нөхцөл, орлого хуваарилах журам”, “Шуудангийн сүлжээ хооронд харилцан холболт хийх, гэрээний ерөнхий нөхцөл, орлого хуваарилах журам”, “Радио, телевизээр сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх, хяналт тавих журам”-д нэмэлт өөрчлөлт оруулах, “Харилцаа холбооны үйлчилгээний тариф тогтоох аргачлал”, “Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ”-г шинэчлэн тогтоох, “Харилцааны радио станцад ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл



шаардлага”, “Радио релейнд ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл шаардлага”, Монгол Улсын үүрэн телефон холбооны үйлчилгээний зах зээлд давамгайллагч үйлчилгээ эрхлэгчийн “Үүрэн холбооны багцын үйлчилгээний тодорхойлолт, багцын үйлчилгээний үнэ тариф”, “Утасгүй холболтын технологийн (Wi-Fi) радио станцад ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл шаардлага”, “Телевизийн өргөн нэвтрүүлгийн станцад ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл шаардлага”, “Нэвтрүүлэх болон хүлээн авах антенны төхөөрөмжийг бүртгэлжүүлэх нөхцөл, шаардлага”, “Харилцаа холбооны богино зайн радио холбооны тоног төхөөрөмжинд ашиглах радио давтамжийн хуваарилалт, техникийн нөхцөл шаардлага” зэрэг нийтдээ 20 гаруй зохицуулалтын баримт бичгээр нэмэлт өөрчлөлт оруулж, шинэчлэн тогтоож баталсан болно.

- ❖ Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалт, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дах заалт, тус хорооны 2013 оны 37 тоот тогтоолоор баталсан “Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийг болон хорооноос хийсэн гүйцэтгэлийн хяналт шалгалтын дүгнэлтийг тус тус үндэслэн 131 хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл шинээр олгох; Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалт, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дах заалт, тус хорооны 2013 оны 37 тоот тогтоолоор баталсан “Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн журам”-ын 10 дугаар зүйлийн 10.2 дах хэсэг, 10.3.1, 10.3.3 дах заалтыг тус тус үндэслэн 24 хуулийн этгээдийн тусгай зөвшөөрлийн хамрах хүрээ ба давтамжийн зурваст нэмэлт өөрчлөлт оруулах; Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.4 дах заалт, 13 дугаар зүйлийн 13.3 дах хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дах заалтыг тус тус үндэслэн 17 хуулийн этгээдийн тусгай зөвшөөрлийг сэргээх; Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.4 дэх заалт, 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дах заалт, тус хорооны дүрмийн 3 дугаар зүйлийн 2.2 дах заалт болон хяналт, шалгалтын ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн 3 хуулийн этгээдийн тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх; Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5 дахь заалт, 14 дүгээр зүйлийн 14.1.1, 14.1.4 дэх заалт, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дэх заалт, 15 дугаар зүйлийн 15.1.3 дэх заалт, тус хорооны 2013 оны 37 тоот тогтоолоор баталсан “Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн журам”-ын 12.1.1 дах заалт болон тухайн аж ахуйн нэгжүүдээс ирүүлсэн хүсэлтүүдийг тус



тус үндэслэн 48 хуулийн этгээдийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгон холбогдох хууль тогтоомжийн дагуу 25 хуулийн этгээдийн тусгай зөвшөөрлийг дуусгавар болгох асуудлыг хэлэлцэн тус тус шийдвэрлэсэн болно.

- ❖ Тайлант хугацаанд, Радио долгионы тухай хууль болон холбогдох журам, зохицуулалтын баримт бичиг, техникийн нөхцөл шаардлага хангасан радио давтамж ашиглах тусгай зөвшөөрөл шинээр авах, хугацаа сунгах, зөвшөөрлийн мэдээлэлд өөрчлөлт оруулах, радио давтамж ашиглах эрхийн бичиг шинээр авах, хугацаа сунгах, нэмэлт өөрчлөлт оруулах, сонирхогчийн радио станц ашиглах хүсэлт гаргасан байгууллага аж ахуйн нэгжийн албан бичиг, сунгалтын өргөдлийн маягт, холбогдох баримт бичигт судалгаа хийх, Радио долгионы тухай хууль болон холбогдох журам, зохицуулалтын баримт бичиг, техникийн нөхцөл шаардлагын дагуу VHF, UHF царанд 215 радио давтамжийн төлөвлөлт оноолт, дүгнэлт гаргаж, олгох асуудлыг шийдвэрлэн хэрэгжилтэнд хяналт тавьж ажилласан.
- ❖ ХХЗХ-ны хуралдааны тогтоол, тэмдэглэлийн хэрэгжилтийг зохион байгуулах, батлагдсан зохицуулалтын чиглэл, дүрэм журам, нөхцөл шаардлагын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт тавих ажлын хүрээнд холбогдох яам, байгууллага, дүүрэг, татварын алба, мэргэжлийн хяналтын газар, ААН, тусгай зөвшөөрөл эзэмшигч, иргэн, хуулийн этгээд нарт 1100 гаруй албан тоотоор тус тус албажуулан хүргүүлэх арга хэмжээг авч ажиллав.
- ХХЗХ-ны 2016 оны хуралдаанаар мэдээллийн технологи, харилцаа холбоо, радио телевиз, шуудангийн зохицуулалтын чиглэл, Дараа үеийн үүрэн холбооны систем нэвтрүүлэх, дүрэм журам, нөхцөл шаардлага, харилцан холболтын орлого хуваах зарчим, зохицуулалтын үйлчилгээний хөлсний зохицуулалт, радио давтамжийн хуваарилалт, төлөвлөлтөнд нэмэлт өөрчлөлт оруулах, шинэчлэх, тусгай зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, цуцлах, сэргээх, баталгаажуулалт, цаг үеийн шаардлагатай байсан зэрэг хэлэлцсэн асуудлаар нийтдээ 52 тогтоол, 19 тэмдэглэлийг тус тус батлан шийдвэрлэж, тогтоол болон тэмдэглэлийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаа.
- “Шуудангийн тухай хууль”-ийн 9.1.2 дах заалтыг үндэслэн Шуудангийн зохицуулалтын газраас боловсруулсан “БНҮҮС-д төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” танилцуулга, тооцоо судалгаа, тогтоолын төслийг хуралдаанаар авч хэлэлцээд, 2017 оны 1 дүгээр сарын 31-ны өдрийн 04 дугаар тогтоолыг батлав. Уг тогтоолоор шуудангийн үйлчилгээ үзүүлэгчээс Бүх нийтийн үйлчилгээний үүргийн санд 2017 онд төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээг шинэчлэн тогтоов. Шуудангийн үйлчилгээ эрхлэгч нь шуудангийн тухайн зах зээлийн ашигтай, зардал багатай хэсэгт үйлчилгээ үзүүлснээр үндсэн сүлжээний Улаанбаатар хотын ашгаас хөдөө орон нутгийн алдагдлыг



нөхөж, хөрөнгө оруулалт хийх, үйлчилгээний үнэ тарифаа тогтоох, орлогоо төлөвлөхөд нөлөөлж байдаг. Иймээс шуудангийн үндсэн сүлжээний алдагдлын тодорхой хувиар БНҮҮС-д төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээг тогтоох зарчмыг баримталсан байна.

- ХХЗХ-ны Даргын 2016 оны А/243 тоот тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг нь Монгол Улсын нутаг дэвсгэрт мэдээлэл, холбооны сүлжээ, дэд бүтэц байгуулах, эзэмших, ашиглах тусгай зөвшөөрөл бүхий мэдээлэл, холбооны сүлжээний үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаанд “Төрийн хяналт шалгалтын тухай”, “Харилцаа холбооны тухай”, “Радио долгионы тухай” хууль, тогтоомж бодлого, зохицуулалтын талаарх тогтоол шийдвэр, тусгай зөвшөөрлийн гэрээгээр хүлээсэн үүрэг, хариуцлага болон нөхцөл шаардлагын хэрэгжилт, тоног төхөөрөмжийн ашиглалт, үйлчилгээ, аюулгүй ажиллагааны байдалд хяналт шалгалт хийж, үнэлэлт, дүгнэлт өгөх, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, гарч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулж, дүгнэлт гаргах, тус хорооны мэдээлэл холбооны сүлжээний ашиглалтын байдалд хийгдсэн судалгаанд нэмэлт мэдээлэл авах, тодруулах, шинэчлэх зорилгоор хяналт шалгалтыг хийж гүйцэтгэсэн байна. Тус ажлын хэсгээс шалгалтын үр дүн, санал дүгнэлт, холбогдох тогтоолын төслийг хуралдаанд танилцуулав. Хуралдаанаар ажлын хэсгийн оруулсан санал, дүгнэлт болон шийдвэрийн төслийг тус тус авч хэлэлцэж, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5 дах заалт, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дах заалт, 15 дугаар зүйлийн 15.1.3 дах заалтыг тус тус үндэслэн 2017 оны 2 дугаар сарын 24-ний өдрийн 07 тоот тогтоолыг баталсан болно. Уг тогтоолд, тусгай зөвшөөрөл авсан өдрөөс хойш 1 жилийн хугацаанд тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагаа явуулж эхлээгүй нь тус хорооноос хийсэн хяналт, шалгалтын ажлын хэсгийн дүгнэлтээр тогтоогдсон тул Мобиком нэтворкс ХХК-ийн 037/A/ICN 03-нэмэлт тоот “Улс хоорондын транзит урсгал дамжуулах үйлчилгээ эрхлэх” тусгай зөвшөөрлийг, Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн 403/A/ICN01-нэмэлт тоот “Улс хоорондын транзит суваг шугам түрээслүүлэх үйлчилгээ эрхлэх” тусгай зөвшөөрлийг тус тус хүчингүй болгов.
- Харилцаа холбооны зохицуулах хороо нь “Радио долгионы тухай” хуулийн 5 дугаар зүйлийн 5.2.3 дахь заалтаар олгогдсон бүрэн эрхийн дагуу Дэд бүтцийн сайдын 2003 оны 216 тоот тушаалаар батлагдсан “Радио давтамжийн ашиглалт, үйлчилгээний төлбөрийн хэмжээ тогтоох журам”-ыг тус тус үндэслэн радио давтамж ашиглалт, үйлчилгээний төлбөрийн хэмжээг тогтоодог. Радио долгионы тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2.3 дах заалт, Дэд бүтцийн сайдын 2003 оны 216 дугаар тушаалаар баталсан “Радио давтамжийн ашиглалт, үйлчилгээний төлбөрийн хэмжээ тогтоох журам”, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 268 дугаар тогтоолоор шинэчлэн батлагдсан “Харилцаа



холбооны зохицуулах хорооны дүрэм"-ийн 2.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн 2017 оны 08 тоот тогтоолын хавсралтаар “Радио давтамжийн ашиглалт, үйлчилгээний төлбөрийн хэмжээ”-г шинэчлэн тогтоож баталсан. Төрөл, ангиллын төлбөрийн хэмжээг радио зурвасын ашиглалтын төлбөр, радио нэвтрүүлэгчийн хүчин чадал/хамрах хүрээний төлбөр, төрөл ангиллын төлбөр гэж тогтоож, тоон технологийн онцлогтой уялдуулсан.

- “Монгол Улсын хэмжээнд радио давтамжийн 2300-2400 МГц-ийн зурвасын зохицуулалт, техникийн нөхцөл шаардлага”, “Монгол Улсын хэмжээнд радио давтамжийн 2500-2690 МГц-ийн зурвасын зохицуулалт, техникийн нөхцөл шаардлага”. Эдгээр баримт бичгүүдийн үндсэн зорилго нь радио давтамжийн 2300-2400 МГц, 2500-2690 МГц-ийн зурваст өндөр хурдны өргөн зурвасын утасгүй холболтын технологийг өргөнөөр ашиглах нэвтрүүлэх, шаардлагатай техникийн нөхцөл шаардлагыг тогтоож, Дараа үеийн хөдөлгөөнт холбооны радио давтамжийн зурвасыг хуваарилах, зурвасыг үр дүнтэй ашиглах нөхцөлийг бүрдүүлэхээр ОУЦХБ, гадаадын 15 зохицуулалтын баримт бичиг (ITU-R M.1036), Европын холбооны СЕРТ стандартчиллын байгууллагын зохицуулалт, стандартыг (ECC-14:02, ECC-11:05, ECC-05:05) судалж боловсруулсан. Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.10 дах заалт, "Харилцаа холбооны зохицуулах хорооны дүрэм"-ийн 2.1.4, 5.4.8 дах заалтыг тус тус үндэслэн хорооны хуралдааны 09 тоот тогтоолын хавсралтаар “Монгол Улсын хэмжээнд радио давтамжийн 2300-2400 МГц-ийн зурвасын зохицуулалт, техникийн нөхцөл шаардлага”; 10 тоот тогтоолын хавсралтаар Монгол Улсын хэмжээнд радио давтамжийн 2500-2690 МГц-ийн зурвасын зохицуулалт, техникийн нөхцөл шаардлага"-ыг тус тус батлав. Энэхүү 2 радио зурвасын зохицуулалт, техникийн нөхцөл шаардлагыг шинээр баталснаар хуучин уг зурвасыг ашиглаж байсан телевиз, радиогийн олон сувгийг дамжуулан хүргэх (MMDS) үйлчилгээ ба утасгүй интернетийн (Wi-MAX) үйлчилгээнээс давтамжийг чөлөөлж, өндөр хурдны өргөн зурвасын утасгүй холболтын шинэ технологи ба интернетийн үйлчилгээ (IMT/BWA)-нд ашиглах, үйлчилгээг өргөжүүлэх, Дараа үеийн хөдөлгөөнт холбооны системд дахин хуваарилж, давтамжийн зурвасыг үр ашигтай ашиглах, хэрэглэгчийн төхөөрөмжийн роуминг хийх боломжийг хангах, хил орчмын радио холбооны үйлчилгээний харилцан зохицолдоог хангах, давтамжийн харилцан нөлөөллөөс хамгаалах боломжийг бүрдүүлж, холбогдох хуваарилалт техникийн нөхцөлийг тогтоож шийдвэрлэв.
- Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын Даргын 2016 оны А/59 тоот тушаалаар шинэчлэн батлагдсан "Монгол Улсын үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгт"-ийн дагуу “Монгол Улсын хэмжээнд харилцааны радио станцад ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл шаардлага”-ын төслийг боловсруулж, тус хорооны хуралдаанаар хэлэлцүүлэв. Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.10 дах заалт,



"Харилцаа холбооны зохицуулах хорооны дүрэм"ийн 2.1.4, 5.4.8 дах заалтыг тус тус үндэслэн 12 дугаар тогтоолын хавсралтаар "Монгол Улсын хэмжээнд харилцааны радио станцад ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл шаардлага" буюу харилцааны радио станцад ашиглах радио давтамжийн зурвасын нарийвчилсан хуваарилалт, ашиглалтын үеийн техникийн нөхцөл шаардлагыг хэрэгжүүлэх, радио давтамжийн харилцан нөлөөллийг арилгах, мэргэжил арга зүйн зөвлөмж, аргачлалаар хангах зохицуулалтыг батлан шийдвэрлэсэн.

- "Тусгай зөвшөөрөл олгох, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох тухай" газар, хэлтсийн боловсруулсан санал, дүгнэлтийг авч хэлэлцээд, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.1.5 дэх заалт, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дах заалт, Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн журмын 10.2 дах хэсэг, 10.3.3 дах заалтыг тус тус үндэслэн 2017 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн 12 тоот "Тусгай зөвшөөрөл олгох, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох тухай" тогтоолыг батлан шийдвэрлэв.
- Хорооны холбогдох бүтцийн нэгжээс хамтран боловсруулсан "Тусгай зөвшөөрлийн ангилалд нэмэлт оруулах (2014 оны 06 тоот тогтоолын хавсралтад нэмэлт оруулах)" асуудлыг хуралдаанаар хэлэлцээд, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.16 дах заалт, Харилцаа холбооны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 9 дүгээр зүйлийн 9.1.2, 9.1.6 болон тус хорооны дүрмийн 2.1, 2.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн тус хорооны 2014 оны 06 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Харилцаа холбооны чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн ангилал"-ын 1 дэх хэсгийн "мэдээлэл холбооны сүлжээ" төрлийн хамрах хүрээ хэсэгт "Улс хоорондын транзит урсгал дамжуулах" гэж нэмэхээр шийдвэрлэв. Энэхүү нэмэлтийг оруулснаар "Харилцаа холбооны чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн ангилал"-д багтаан тусгай зөвшөөрөл эзэмшигч нь "мэдээлэл холбооны сүлжээ" төрлийн үйлчилгээний хамрах хүрээг "Улс хоорондын транзит урсгал дамжуулах" чиглэлээр нэмэгдүүлэх боломж бүрдэв.
- Тус хорооны баталсан 2017 оны 07 тоот тогтоол, шийдвэрийн талаар ЗГХЭГ-ын дэргэдэх Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зөвлөлөөс гаргасан 2017 оны 4 дүгээр сарын 14-ны өдрийн 01 дугаар зөвлөмжийн талаар талаар танилцуулга, ШӨХТГ-ын дүгнэлт, Хорооны удирдлага болон Мобиком Корпораци ХХК, Мобиком нэтворкс ХХК-ийн ерөнхий захирал, холбогдох хүмүүстэй хийсэн уулзалтын үр дүн, Мобиком нэтворкс ХХК-иас ирүүлсэн нэмэлт материалын талаар гаргасан дүгнэлт, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний саналын тухай асуудлыг авч хэлэлцсэн болно. Мобиком нэтворкс ХХК-иас транзитын үйл ажиллагааг эрхлэн явуулахад тодорхой түвшинд эхлэл нь бүрдсэн байна гэж дүгнэсэн тул Эдийн засгийн түншлэлийн тухай Монгол-Японы хэлэлцээр, Дэлхийн худалдааны байгууллагын гэрээ, Захиргааны



ерөнхий хуулийн холбогдох заалтын дагуу тус компаний 037/A/ICN03 тоот Монгол Улсын нутаг дэвсгэрт “Харилцаа холбооны сүлжээ байгуулах, эзэмших, түүний ашиглалт үйлчилгээ эрхлэх” тусгай зөвшөөрлийн хамрах хүрээнд “Улс хоорондын транзит урсгал дамжуулах” гэж хорооны “Тусгай зөвшөөрөл олгох, нэмэлт, өөрчлөлт оруулах, сэргээх тухай” тогтоолын хавсралтад нэмж оруулахаар шийдвэрлэв. Хорооны хуралдаанаар тусгай зөвшөөрөл олгох, нэмэлт, өөрчлөлт оруулах, сэргээх тухай газар, хэлтсийн боловсруулсан санал, дүгнэлтийг авч хэлэлцээд, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 13.3 дах заалт, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дах заалт, Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн журмын 10.2 дах хэсэг, 10.3.3 дах заалтыг тус тус үндэслэн тус тус үндэслэн 2017 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн 14 тоот “Тусгай зөвшөөрөл олгох, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох тухай” тогтоолыг батлав.

- Хуралдаанд Монгол Улсын Сонгуулийн тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.17-д заасны дагуу Сонгуулийн ерөнхий хороо (СЕХ), Харилцаа холбооны зохицуулах хорооны 2016 оны 29/17 дугаар хамтарсан тогтоолоор баталсан “Радио, телевизээр сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх, хяналт тавих журам”-ыг нийтээр дагаж мөрдөх улсын нэгдсэн санд бүртгүүлэхээр хянуулах явцад ХЗДХЯ-наас албан тоотоор санал, дүгнэлтээ ирүүлсэн болно. Дүгнэлтээр уг журмын 2.3, 2.6, 2.7, 3.1, 3.3, 3.6, 3.7, 3.8, 3.11, 4.3, 4.5 дах заалтууд Сонгуулийн тухай хуулийн холбогдох зүйлүүдтэй давхардсан тул Захиргааны ерөнхий хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.8-д заасан “бусад хуулийн заалтыг давхардуулан заалгүйгээр шаардлагатай тохиолдолд эшлэл хийгдсэн байх” гэсэн шаардлагад нийцүүлэх шаардлагатай гэж үзсэн бөгөөд дээрх журамд хуулийн заалтуудтай давхардсан зүйлийн 14 заалтуудыг хасах, 1 заалтыг өөрчлөн найруулж боловсруулах ажлыг СЕХ, ХХЗХ-ны холбогдох мэргэжилтэн, хуульчдын баг хамтран гүйцэтгэсэн. Тус хуралдаанаар уг асуудлыг авч хэлэлцээд, Сонгуулийн Ерөнхий Хороо, ХХЗХ-ны 2016 оны 29/17 тоот хамтарсан тогтоолын хавсралтаар баталсан “Радио, телевизээр сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх, хяналт тавих журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулан СЕХ, ХХЗХ-ны хамтарсан “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” тогтоолыг батлав. СЕХ болон ХХЗХ-ноос ХЗДХЯ-нд энэхүү журмын өөрчлөлтийг нийтээр даган мөрдөх хэм хэмжээнд хянуулан бүртгүүлэв (ХЗДХЯ-ны Захиргааны хэм, хэмжээ тогтоосон шийдвэрийн улсын бүртгэлийн **3726** дугаар). Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем (www.legalinfo.mn), хорооны цахим хуудас (www.csg.gov.mn)-д тус тус байршуулсан болно.
- Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх хэсэгт “сүлжээ хооронд харилцан холболт хийх гэрээний ерөнхий нөхцөл, орлого хуваарилах журмыг батлах”; 9.1.5 дах хэсэгт “*харилцаа холбооны үйлчилгээний тариф тогтоох аргачлалыг батлах, зах зээлд давамгайлж буй үйлчилгээний*



- журам”-ыг, хоёрдугаар хавсралтаар “Шуудангийн сүлжээ хооронд харилцан холболт хийх, гэрээний ерөнхий нөхцөл, орлого хуваарилах журам”-ыг тус тус шинэчлэн баталсан болно.
- Хорооны хуралдаанаар баталсан 2017 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 16 тоот тогтоолыг хорооны Даргын 2017 оны 5 дугаар сарын 04-ний өдрийн 01/575 албан ХЗДХЯ-нд улсын бүртгэлд бүртгүүлэхээр хүргүүлж, ХЗДХЯ-ны Захиргааны хэм, хэмжээ тогтоосон шийдвэрийн улсын бүртгэлийн **3731** дугаарт хавсралт-1-ыг 2017 оны 5 дугаар сарын 25-ны өдөр бүртгүүлсэн. Уг тогтоолын 2 дугаар хавсралтыг Захиргааны ерөнхий хуулийн дагуу Хууль, зүй дотоод хэргийн яам хянан үзэж, захиргааны хэм, хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд **3732** дугаарт бүртгэсэн ба эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем (www.legalinfo.mn), хорооны цахим хуудас (www.crc.gov.mn)-д байршуулав.
 - Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.1.4, 10.1.5 дах заалт, 13 дугаар зүйлийн 13.3 дах хэсэг, 14 дүгээр зүйлийн 14.1.1 дэх заалт, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дах заалтыг тус тус үндэслэн “Тусгай зөвшөөрөл олгох, сэргээх, хүчингүй болгох тухай” 2017 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 17 тоот 3 хавсралт бүхий тогтоолыг батлав. Энэхүү тогтоолын хавсралтаар 9 хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох, 1 хуулийн этгээдийн тусгай зөвшөөрлийг сэргээх, 1 хуулийн этгээдийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох асуудлыг тус тус хэлэлцэн шийдвэрлэсэн.
 - “Тусгай зөвшөөрөл олгох тухай”, “Тусгай зөвшөөрөлд өөрчлөлт оруулах тухай”, “Тусгай зөвшөөрөл сэргээх тухай”, “Тусгай зөвшөөрөл хүчингүй болгох тухай” газар, хэлтсийн боловсруулсан танилцуулга, дүгнэлт болон тогтоолын төслийг авч хэлэлцэв. Хэлэлцсэн асуудлаар дараах тогтоолыг батлан шийдвэрлэв.
 - 2017 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн А/17 тушаалаар байгуулагдсан ажлын хэсгээс удирдамжийн дагуу хийсэн хяналт, шалгалтын ажлын хэсгийн санал, дүгнэлт болон “Тусгай зөвшөөрлийн хугацаа дуусгавар болсон Монгол Улс, Улаанбаатар хотод кабелийн сувгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн талаар танилцуулга, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” асуудлыг танилцуулав. Хуралдаанаас “Зарим тусгай зөвшөөрлийг дуусгавар болгох тухай” хуралдааны тэмдэглэлийг “Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн журам”-ын 8.1, 8.12, 12.7 заалтыг тус тус үндэслэн гаргаж, Улаанбаатар хот, Монгол Улсад хамрах хүрээний кабелийн сувгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй боловч үйл ажиллагаа явуулаагүй, эхлүүлээгүй, тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан, сунгалтын хүсэлтийг тус хороонд албан ёсоор ирүүлээгүй нэр бүхий 3 хуулийн этгээдийн (Молор трейд ХХК, Кэй Си Би Эн ХХК, Маст технологи ХХК) тусгай зөвшөөрлийг дуусгавар болгохоор шийдвэрлэв.



- “Харилцааны радио станцад ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл шаардлага”-ыг 2013 оны 16 дугаар тогтоол, 2013 оны 17 дугаар тогтоол, 2013 оны 25 дугаар тогтоол, 2015 оны 11 дүгээр тогтоол, 2015 оны 59 дүгээр тогтоол, 2017 оны 11 дүгээр тогтоолоор тус тус батлан мөрдөж байна. Түүнчлэн “Радио релейнд ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл шаардлага”-ыг хорооны 2014 оны 9 дүгээр тогтоол, 2014 оны 20 дугаар тогтоол, 2014 оны 30 дугаар тогтоол, 2014 оны 54 дүгээр тогтоол, 2015 оны 18 дугаар тогтоол, 2015 оны 23 дугаар тогтоолоор батлан хүчин төгөлдөр мөрдөж ирсэн болно. Эдгээр 2 радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл шаардлагын баримт бичгийг Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэх, тогтоолуудыг нэгтгэн нэг баримт бичиг болгох, тус хороонд хуулиар эрх олгосон заалтын томъёолол, агуулгад нийцүүлж, өөрчлөн найруулсан байна. Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3 дэх заалт, 9.1.10 дах заалт, Радио долгионы тухай хуулийн 3.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн тус хорооны хуралдааны 2017 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 31 тоот тогтоолын хавсралтаар “Харилцааны радио станцад ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл шаардлага”-ыг; 2017 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 32 тоот тогтоолын хавсралтаар “Радио релейнд ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл шаардлага”-ыг тус тус батлан шийдвэрлэв.
- Телевиз, радиогийн олон суваг дамжуулах үйлчилгээний зах зээлд интернет протоколд суурилсан Ай-Пи-ТВ үйлчилгээ эрхлэгч 3; телевизийн олон суваг (CaTV, MMDS) 44; Хиймэл дагуул (VSAT)-аар телевизийн олон сувгийг дамжуулах үйлчилгээ эрхлэгч 3; мобайл сүлжээгээр дамжуулах үйлчилгээ эрхлэгч 1 тус тус байна.
- Харилцаа холбооны зохицуулах хороо нь Сонгуулийн тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.18-д заасан чиг үүргийн дагуу тусгай ажлын хэсэг байгуулж, радио, телевизээр нэвтрүүлсэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуулийн сурталчилгаанд 2017 оны 6 дугаар сарын 05-ны өдрөөс 7 дугаар сарын 08-ны өдрийн хооронд нийт 34 хоногийн хугацаанд хяналт тавьж, хэрэгжилтийг хангуулах талаар холбогдох арга хэмжээ авч ажилласан болно. Сонгуулийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд www.cgc.gov.mn дэд цэс нээж “Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль-2017” хуудас нээж, сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх, хяналт тавих үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомж, холбогдох мэдээ, мэдээлэл, зөвлөмжийг тухай бүр гаргаж, хяналтын дүн мэдээ, тайланг 7 хоногоор тухай бүр олон нийтэд мэдээлж байсан. Тус хороо нь сонгуулийн сурталчилгааны үеэр радио, телевизийн үйлчилгээ эрхлэгчдийг сурталчилгаа нэвтрүүлэхдээ Сонгуулийн тухай болон холбогдох хууль тогтоомжийг зөрчихгүй байлгах үүднээс анхааруулсан албан тоотыг 2-3 удаа хүргүүлж, хяналт мониторингийн



дүнд үндэслэн анхааруулах, сануулах болон илэрсэн зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээг авч ажилласан.

- Олон улсын цахилгаан холбооны байгууллагын зөвлөмжүүд, олон улсын харилцаа холбооны хөгжлийн хандлагын дагуу Монгол Улсын үүрэн холбооны үйлчилгээ эрхлэгчид тухайн зах зээлд өөрийн үндсэн үйлчилгээний үнэ тарифыг тогтоохдоо яриа, өгөгдөл, богино үсэгт мэдээ (SMS) хосолсон багц хэлбэрт шилжүүлэх болсон. Ингэснээр давамгайл байдалтай үйлчилгээ эрхлэгч багцын үйлчилгээ гэсэн нэрийн доор тус хорооны 2016 оны 01 тогтоолоор батлагдсан стандарт үнийн үйлчлэлд орохгүй олон төрлийн үйлчилгээ шинээр нэвтрүүлж байна. Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газраас 2017 оны 5 сард “Монгол Улсын харилцаа холбооны үйлчилгээний үнэ тариф, өрсөлдөөний талаар баримтлах бодлогын чиглэл”-ийг шинэчлэн баталж, харилцаа холбооны салбарын үнэ тариф, өрсөлдөөний талаарх зохицуулалтыг боловсронгуй болгох боломжийг бүрдүүлсэн. Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.5 дах хэсгийг үндэслэн 2017 оны 7 дугаар сарын 28-ны өдрийн “Үнэ тариф тогтоох тухай” 34 дугаар тогтоолыг батлан гаргалаа. Энэхүү тогтоолын хавсралтаар “Үүрэн холбооны багцын үйлчилгээний тодорхойлолт, багцын үйлчилгээний үнэ тариф”-ыг тогтоож батлав. Үүрэн холбооны үйлчилгээ эрхлэгчдийн үндсэн үйлчилгээний 1 минутын үнэ тарифид хяналт тавихаас илүүтэйгээр хэрэглэгчид санал болгож буй багцын үйлчилгээнүүд, багцын үйлчилгээний орц буюу багцад хамрагдаж буй үйлчилгээний нэр төрлүүдийг оновчтой зөв тодорхойлох, багцын орцод нэрлэгдэж буй тухайн үйлчилгээний амлалтыг хэрхэн тооцоолох, салбарын эдийн засгийн үр ашгийг хадгалж байх үүднээс үйлчилгээ эрхлэгчийн 1 хэрэглэгчээс олох орлого (ARPU)-ын хэмжээг тогтвортой байлгах, доод хэмжээг тодорхойлох, сүлжээндээ хязгааргүй ярих эрх олгох тарифын доод хэмжээг 1 хэрэглэгчээс олох орлого (ARPU)-той холбож тогтоох зэрэг зохицуулалтын асуудлыг шийдвэрлэх боломжийг бүрдүүлж эхлээд байна.
- Тус хорооны ЗБХГ-аас боловсруулсан өргөн нэвтрүүлгийн зохицуулалт болон өргөн нэвтрүүлгийн зохицуулалт, нөхцөл шаардлагад оруулах зарчмын гол өөрчлөлтийн санал; Өргөн нэвтрүүлгийн зохицуулалт, нөхцөл шаардлагаас хуулийн давхардсан болон зөвлөмжөөр тусгах шаардлагатай гэж үзсэн заалтуудыг хасч, тусад нь “Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэхэд баримтлах зөвлөмж” нэрээр гаргах; “Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэхэд баримтлах зөвлөмж”-ийн төсөл, “Өргөн нэвтрүүлгийн хөтөлбөрт хүүхэд хамгаалах чиглэлээр баримтлах зарчим” зөвлөмжийн төсөл, танилцуулгыг тус тус авч хэлэлцээд, тус хуралдаанаас өргөн нэвтрүүлгийн зохицуулалтын баримт бичигт оруулах нэмэлт, өөрчлөлтийн санал болон холбогдох зөвлөмжүүдийг тусад нь гаргах нь зүйтэй гэж тогтов.



- Зохицуулах хорооны 2017 оны ээлжит 8 дугаар хуралдаанаас өгсөн чиглэлийн дагуу (Хорооны хуралдааны 2017 оны 12 дугаар тэмдэглэл) хорооны даргын 2017 оны А/210 тоот тушаалаар тоон контентийн зохицуулалтын өнөөгийн нөхцөл байдлын талаар дүгнэлт гаргах, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулах, хууль эрх зүйн шийдлийг тодорхойлох зорилготой ажлын хэсгийг байгуулсан болно. Ажлын хэсгийн хэсгээс “Онлайн контентийн зохицуулалтын хууль эрх зүйн шийдэл: олон улсын туршлага, өнөөгийн хууль эрх зүйн орчин” судалгааны ажлын явцын талаар танилцуулгыг тус хорооны хуралдаанд хэлэлцүүлсэн.
- Харилцаа холбооны зохицуулах хорооны 2017 оны 7 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаанаар “Үнэ тариф батлах тухай” 2017 оны 34 дүгээр тогтоолыг баталсан бөгөөд тогтоолын хавсралтаар үүрэн телефон холбооны үйлчилгээний зах зээлд давамгайллагч үйлчилгээ эрхлэгчийн “Үүрэн холбооны багцын үйлчилгээний тодорхойлолт, багцын үйлчилгээний үнэ тариф”-ыг тогтоож баталсан юм. Тус хорооноос энэхүү тогтоолыг Захиргааны ерөнхий хуулийн дагуу ХЗДХЯ-аар хянуулж захиргааны хэм, хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхээр албан тоотоор хүргүүлсэн боловч тус яамнаас 2017 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн 1-1/3780 тоотоор ирүүлсэн хариу албан бичигт Захиргааны ерөнхий хуулийн 66.3.3-д заасны дагуу Хорооны 2017 оны 34 тоот тогтоолыг эрх зүйн мэдээллийн нэгдсэн системд бүртгэх шаардлагагүй гэж үзсэн болно.
- Харилцаа холбооны зохицуулах хороо нь “Радио долгионы тухай” хуулийн 5 дугаар зүйлийн 5.2.3-т заасан бүрэн эрхийн дагуу Дэд бүтцийн сайдын 2003 оны 216 дугаар тушаалаар батлагдсан “Радио давтамжийн ашиглалт, үйлчилгээний төлбөрийн хэмжээ тогтоох журам”-ыг үндэслэн Радио давтамжийн ашиглалт, үйлчилгээний төлбөрийн хэмжээг тогтоодог. “Радио давтамжийн ашиглалт, үйлчилгээний төлбөрийн хэмжээ”-г тогтоосон Харилцаа холбооны зохицуулах хорооны 2017 оны 2 дугаар сарын 24-ний өдрийн 08 тоот тогтоолыг Захиргааны ерөнхий хуулийн дагуу хянуулан, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн юм. Хууль зүй, дотоод хэргийн яамнаас тус хороо нь Радио долгионы тухай хуулийн 5.2.3 дах заалтаар өөрт олгогдоогүй эрх хэмжээг эдэлж радио давтамжийн ашиглалт, үйлчилгээний төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоож байгаа нь Захиргааны ерөнхий хуулийн 60.1.3, 60.1.7 дах заалтыг хангахгүй байгаа мөн 64.1 дэх заалттай нийцээгүй тул бүртгэхээс татгалзсан 1-1/4112 тоот дүгнэлтийг тус хороонд ирүүлсэн болно. Иймээс тус хорооны холбогдох газар хамтран ХЗДХЯ-наас ирүүлсэн зөвлөмж, дүгнэлтэд нийцүүлэн ХХЗХ-ны 2017 оны 08 тоот тогтоолыг хүчингүй болгох, “Радио давтамжийн ашиглалт, үйлчилгээний төлбөрийн хэмжээ”-г зөвлөмжийг тусган шинэчлэн тогтоож батлах тухай танилцуулга, тогтоолын төсөл, хавсралт



баримт бичгийг боловсруулж, хэлэлцүүлсэн болно. Радио долгионы тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2.3-т заасан бүрэн эрхийн дагуу Дэд бүтцийн сайдын 2003 оны 216 дугаар тушаалаар батлагдсан “Радио давтамжийн ашиглалт, үйлчилгээний төлбөрийн хэмжээ тогтоох журам”, Засгийн газрын 2016 оны 268 дугаар тогтоолоор батлагдсан “Харилцаа холбооны зохицуулах хорооны дүрэм”-ийн 2.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн 2017 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 57 дугаар тогтоолыг баталж, тогтоолын хавсралтаар “Радио давтамжийн ашиглалт, үйлчилгээний төлбөрийн хэмжээ”-г шинэчлэн тогтоож байна.

- ❖ ХХЗХ-ны 2017 оны хуралдааны тогтоол шийдвэр, тэмдэглэлийн хэрэгжилтийг зохион байгуулах, батлагдсан зохицуулалтын чиглэл, дүрэм журам, нөхцөл шаардлагын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт тавих ажлын хүрээнд холбогдох яам, байгууллага, дүүрэг, татварын алба, мэргэжлийн хяналтын газар, ААН, тусгай зөвшөөрөл эзэмшигч, иргэн, хуулийн этгээд нарт 1500 гаруй албан тоотоор тус тус албажуулан хүргүүлэх арга хэмжээг авч ажиллав.
- ❖ Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэх, өөрчлөлт оруулах, шинэчлэн тогтоож 2017 оны хуралдаанаар баталсан “Радио давтамжийн ашиглалт, үйлчилгээний төлбөрийн хэмжээ”; “Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ”-г шинэчлэн тогтоох, “Сүлжээ хооронд харилцан холболт хийх, гэрээний ерөнхий нөхцөл, орлого хуваарилах журам”, “Шуудангийн сүлжээ хооронд харилцан холболт хийх, гэрээний ерөнхий нөхцөл, орлого хуваарилах журам”, “Радио, телевизээр сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх, хяналт тавих журам”-д нэмэлт өөрчлөлт оруулах, “Харилцаа холбооны үйлчилгээний тариф тогтоох аргачлал”, “Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ”-г шинэчлэн тогтоох, “Харилцааны радио станцад ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл шаардлага”, “Радио релейнд ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл шаардлага”, Монгол Улсын үүрэн телефон холбооны үйлчилгээний зах зээлд давамгайлалт үйлчилгээ эрхлэгчийн “Үүрэн холбооны багцын үйлчилгээний тодорхойлолт, багцын үйлчилгээний үнэ тариф”, “Утасгүй холболтын технологийн (Wi-Fi) радио станцад ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл шаардлага”, “Телевизийн өргөн нэвтрүүлгийн станцад ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл шаардлага”, “Нэвтрүүлэх болон хүлээн авах антенны төхөөрөмжийг бүртгэлжүүлэх нөхцөл, шаардлага”, “Харилцаа холбооны богино зайн радио холбооны тоног төхөөрөмжинд ашиглах радио давтамжийн хуваарилалт, техникийн нөхцөл шаардлага” зэрэг нийтдээ 20 гаруй зохицуулалтын баримт бичгийг ХЗДХЯ-ны Захиргааны хэм, хэмжээ тогтоосон шийдвэрийн улсын бүртгэлийн санд



- бүртгүүлэх, албан ёсны дүгнэлт зөвлөмж авах, түүний дагуу тогтоол шийдвэрийг нийцүүлэх, шинэчлэх арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.
- ❖ ХХЗХ-ны 2017 оны ээлжит 11 удаа, ээлжит бус 1 удаагийн хуралдаанаар асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн нийт 58 тогтоол, шийдвэрийн дэлгэрэнгүй судалгааг гаргаж, хорооны хуралдаанаар батлагдсан тогтоол, тогтоолын хавсралтуудыг тусгай фолдерт байршуулан албан дотоод хэрэгцээнд ашиглах боломжийг бүрдүүлэх ажилласан. Түүнчлэн салбарын зохицуулалтын баримт бичиг, дүрэм журам, тусгай зөвшөөрлийн шинээр батлагдсан, шинэчилсэн, нэмэлт өөрчлөлт оруулсан журам, нөхцөл шаардлага болон 2017 оны хорооны хуралдааны шийдвэр, тогтоолын хавсралтыг татах файлын хамт HTML хэлбэрээр оруулж, олон нийтэд нээлттэй сурталчилах, зөвлөмж гарын авлага хэлбэрээр ашиглах боломжийг бүрдүүлэн ажилласан болно.
 - ❖ Хорооны 11 удаагийн ээлжит болон 1 удаагийн ээлжит бус хуралдааны мэдээлэл болон тогтоол, тэмдэглэл, батлагдсан баримт бичгийг хавсралтын хамт, тайлан мэдээллийг тухай бүр байгууллагын цахим хуудаст байршуулан мэдээллийн ил тод байдлыг хангах, олон нийтэд сурталчлах, хорооны шийдвэрийг нээлттэй болгон ажиллаа.
 - ❖ ХХЗХ-ноос мэдээлэл, харилцаа холбооны салбарын хурдацтай хөгжил, бизнесийн нэгдэн нийлэлт, хөрөнгө оруулалт, мэдээлэлжсэн нийгмийн хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлага нь манай салбарын хөгжлийг илүү хурдасгах, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, оновчтой бодлого, зохицуулалт, эрх зүйн таатай орчныг шаардаж байгаа төдийгүй бид бүхэн мэдлэг туршлагаа нэгтгэж, хамтдаа хөгжих, салбарын болон салбар хоорондын уялдаа холбоог шинэ шатанд гаргах зорилгоор ЗГХЭГ, төрийн яам, байгууллага, олон улсын байгууллага, харилцаа холбооны салбарын үйлчилгээ эрхлэгч, бизнесийн салбарын болон төрийн бус байгууллагын төлөөллийг хамруулсан “Монгол Улсын хөгжилд мэдээлэл харилцаа холбооны манлайлал, чиг хандлага” сэдэвт хэлэлцүүлэг, хурлыг 2017 оны 11 сард зохион байгуулж, шинэ орчинд нийцсэн эрх зүйн орчинг шинэчлэх, мэдээлэл харилцаа холбооны нэгдсэн бодлого, төлөвлөлтөөр хангах механизмыг бүрдүүлэх, төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг сайжруулах, нийгэм эдийн засгийн бүх салбарт харилцаа холбооны ололт, үйлчилгээг нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах, салбарын хөгжлийг олон улсын тэргүүн туршлага, хөгжлийн чиг хандлагатай уялдуулах зэрэг чиглэлээр зөвлөмжийг хэлэлцэн баталж, хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг гарган ажиллаж байна.
 - ❖ Тусгай зөвшөөрөл эзэмшигч, хэрэглэгч нарт чиглэсэн сургалт, бүсийн семинар зэрэг арга хэмжээг зохион байгуулж, мэргэжил арга зүйн зөвлөмж үзүүлсэн болно.



- ❖ Монгол Улсын мэдээллийн технологи, харилцаа холбооны хөгжлийн бодлого, нэгдсэн бодлого, төлөвлөлтийг бэхжүүлэх, төрийн захиргааны байгууллагын бодлогын хүрээнд зохицуулалт, өрсөлдөөний орчинг боловсронгуй болгосноор мэдээллийн технологи, харилцаа холбооны салбарын зохицуулалтын арга хэрэгслээр зах зээлийн өрсөлдөөнийг дэмжих, мэдээллийн дэд бүтцийг бий болгоход дэмжлэг үзүүлэх, цахим засаглалыг бий болгох, шинэлэг бүтээлч үйл ажиллагаанд тулгуурлан эрэлт, хэрэгцээг хангасан шинэ төрлийн хэрэглээ, үйлчилгээг нэвтрүүлэх, дэмжих эрх зүйн шинэ зохицуулалт хэрэгтэй юм.

Хавсралт-1:

**ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ХУРАЛДААНААС 2017 ОНД БАТАЛСАН ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН
НЭГДСЭН СУДАЛГАА**

2017.12.06

<i>№</i>	<i>Хорооны баталсан тогтоол, тэмдэглэлийн дугаар</i>	<i>Огноо</i>	<i>Тогтоол, тэмдэглэлийн товч агуулга</i>
<i>Нэг. ХХЗХ-ны баталсан тогтоол</i>			
1	Тогтоол 01	2017.01.31	Нэмэлт, өөрчлөлт оруулах тухай



			(Харилцаа холбооны зохицуулах хорооны хуралдааны дэг)
2	Тогтоол 02	2017.01.31	Тогтоолд өөрчлөлт оруулах тухай (2016 оны 44 тоот тогтоол)
3	Тогтоол 03	2017.01.31	Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай (2015 оны 21 тоот тогтоол)
4	Тогтоол 04	2017.01.31	БНҮҮС-д 2017 онд төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай
5	Тогтоол 05	2017.01.31	Тусгай зөвшөөрөл олгох, өөрчлөлт оруулах, сэргээх, түдгэлзүүлэх, хүчингүй болгох тухай
6	Тогтоол 06	2017.02.24	Тусгай зөвшөөрөл олгох, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох тухай
7	Тогтоол 07	2017.02.24	Тусгай зөвшөөрөл хүчингүй болгох тухай
8	Тогтоол 08	2017.02.24	“Радио давтамжийн ашиглалт, үйлчилгээний төлбөрийн хэмжээ”-г шинэчлэн тогтоох тухай
9	Тогтоол 09	2017.03.31	Радио давтамжийн 2300-2400МГц-ийн зурвасын зохицуулалт, техникийн нөхцөл шаардлага батлах тухай
10	Тогтоол 10	2017.03.31	Радио давтамжийн 2500-2690МГц-ийн зурвасын зохицуулалт, техникийн нөхцөл шаардлага батлах тухай
11	Тогтоол 11	2017.03.31	Харилцааны радио станцад ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл шаардлага батлах тухай
12	Тогтоол 12	2017.03.31	Тусгай зөвшөөрөл олгох, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох тухай
13	Тогтоол 13	2017.04.14	Тусгай зөвшөөрлийн ангилалд нэмэлт оруулах тухай
14	Тогтоол 14	2017.04.14	Тусгай зөвшөөрөл олгох, нэмэлт, өөрчлөлт оруулах, сэргээх тухай
15	Тогтоол 12/15	2017.04.14	Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (СЕХ, ХХЗХ-ны 2016 оны 29/17 тоот хамтарсан тогтоол: “Радио, телевизээр сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх, хяналт тавих журам”)
16	Тогтоол 16	2017.04.28	Журам шинэчлэн батлах тухай (Хавсралт-1: “Сүлжээ хооронд харилцан холболт хийх, гэрээний ерөнхий нөхцөл, орлого хуваарилах журам”, Хавсралт-2: “Шуудангийн сүлжээ хооронд харилцан холболт хийх, гэрээний ерөнхий нөхцөл, орлого хуваарилах журам”)



17	Тогтоол 17	2017.04.28	Тусгай зөвшөөрөл олгох, сэргээх, хүчингүй болгох тухай
18	Тогтоол 18	2017.04.28	Аргачлал батлах тухай ("Харилцаа холбооны үйлчилгээний тариф тогтоох аргачлал")
19	Тогтоол 19	2017.05.31	"Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ"-г шинэчлэн тогтоох тухай
20	Тогтоол 20	2017.05.31	Сонгон шалгаруулалт зохион байгуулах тухай ("Улаанбаатар хотод хэт богино долгионы радиогийн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх, радио давтамж ашиглах тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалт")
21	Тогтоол 21	2017.05.31	Үндсэн хөрөнгө ашиглалтаас хасч, актлах тухай
22	Тогтоол 22	2017.05.31	Тусгай зөвшөөрөл олгох тухай
23	Тогтоол 23	2017.05.31	Тусгай зөвшөөрөлд өөрчлөлт оруулах тухай
24	Тогтоол 24	2017.05.31	Тусгай зөвшөөрөл сэргээх тухай
25	Тогтоол 25	2017.05.31	Тусгай зөвшөөрөл хүчингүй болгох тухай
26	Тогтоол 26	2017.06.30	Тогтоол хүчингүй болгох тухай (2012 оны 78 тоот тогтоол)
27	Тогтоол 27	2017.06.30	Тусгай зөвшөөрөл олгох тухай
28	Тогтоол 28	2017.06.30	Тусгай зөвшөөрөлд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
29	Тогтоол 29	2017.06.30	Тусгай зөвшөөрөл сэргээх тухай
30	Тогтоол 30	2017.06.30	Тусгай зөвшөөрөл хүчингүй болгох тухай
31	Тогтоол 31	2017.06.30	Харилцааны радио станцад ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл шаардлага тогтоож, батлах тухай
32	Тогтоол 32	2017.06.30	Радио релейнд ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл шаардлага тогтоож, батлах тухай
33	Тогтоол 34	2017.07.28	Үнэ тариф тогтоох тухай (Үүрэн холбооны багцын үйлчилгээний үнэ тариф)
34	Тогтоол 35	2017.07.28	Тусгай зөвшөөрөл олгох тухай
35	Тогтоол 36	2017.07.28	Тусгай зөвшөөрөлд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
36	Тогтоол 37	2017.07.28	Тусгай зөвшөөрөл хүчингүй болгох тухай
37	Тогтоол 38	2017.08.30	Тусгай зөвшөөрөл олгох тухай
38	Тогтоол 39	2017.08.30	Тусгай зөвшөөрөлд өөрчлөлт оруулах тухай
39	Тогтоол 40	2017.08.30	Тусгай зөвшөөрөл олгох тухай
40	Тогтоол 41	2017.09.28	Утасгүй холболтын технологийн (Wi-Fi) радио станцад ашиглах радио давтамжийн зурвасын



			хуваарилалт, техникийн нөхцөл шаардлагыг тогтоож, батлах тухай
41	Тогтоол 42	2017.09.28	Телевизийн өргөн нэвтрүүлгийн станцад ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл шаардлагыг тогтоож, батлах тухай
42	Тогтоол 43	2017.09.28	Нэвтрүүлэх болон хүлээн авах антенны төхөөрөмжийг бүртгэлжүүлэх нөхцөл шаардлагыг тогтоож, батлах тухай
43	Тогтоол 44	2017.09.28	Богино зайн радио холбооны тоног төхөөрөмжийн радио давтамжийн хуваарилалт, техникийн нөхцөл шаардлага тогтоож, батлах тухай
44	Тогтоол 45	2017.09.28	Тусгай зөвшөөрөл олгох тухай
45	Тогтоол 46	2017.09.28	Тусгай зөвшөөрөлд өөрчлөлт оруулах тухай
46	Тогтоол 47	2017.10.27	Тусгай зөвшөөрөл олгох тухай
47	Тогтоол 48	2017.10.27	Тусгай зөвшөөрөлд өөрчлөлт оруулах тухай
48	Тогтоол 49	2017.10.27	Тусгай зөвшөөрөл сэргээх тухай
49	Тогтоол 50	2017.10.27	Тусгай зөвшөөрөл хүчингүй болгох тухай
50	Тогтоол 51	2017.10.27	Нөхцөл шаардлагад өөрчлөлт оруулах тухай (2017 оны 43 тоот тогтоол: Нэвтрүүлэх болон хүлээн авах антенны төхөөрөмжийг бүртгэлжүүлэх нөхцөл шаардлагыг тогтоож, батлах тухай)
51	Тогтоол 52	2017.11.30	Тусгай зөвшөөрөл олгох тухай
52	Тогтоол 53	2017.11.30	Тусгай зөвшөөрөлд өөрчлөлт оруулах тухай
53	Тогтоол 54	2017.11.30	Тусгай зөвшөөрөл сэргээх
54	Тогтоол 55	2017.11.30	Тусгай зөвшөөрөл түдгэлзүүлэх тухай
55	Тогтоол 56	2017.11.30	Тусгай зөвшөөрөл хүчингүй болгох тухай
56	Тогтоол 57	2017.11.30	“Радио давтамжийн ашиглалт, үйлчилгээний төлбөрийн хэмжээ”-г шинэчлэн тогтоож батлах тухай
57	Тогтоол 58	2017.11.30	“Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ”-г шинэчлэн тогтоож батлах тухай
Хоёр. Хорооны хуралдааны тэмдэглэл			
1	Тэмдэглэл-01	2017.01.31	Хорооны хуралдааны 2016 оны жилийн эцсийн тайлан, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн тухай
2	Тэмдэглэл-02	2017.02.24	Хяналт шалгалтын үйл ажиллагааны талаар баримтлах удирдамж, чиглэлийн тухай
3	Тэмдэглэл-03	2017.02.24	Тусгай зөвшөөрлийн талаар авах зарим арга хэмжээний тухай (Транзит: Хүчингүй болгох)



4	Тэмдэглэл-04	2017.02.24	Радио давтамжийн ашиглалт, үйлчилгээний төлбөрийн талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай
5	Тэмдэглэл-05	2017.04.14	Тусгай зөвшөөрлийн талаар авах зарим арга хэмжээний тухай (Транзит: Нэмэлт оруулах)
6	Тэмдэглэл-06	2017.04.28	Тусгай зөвшөөрлийн талаар гаргасан тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах тухай
7	Тэмдэглэл-07	2017.05.31	Тусгай зөвшөөрлийг дуусгавар болгох тухай
8	Тэмдэглэл-08	2017.06.30	Сувгийн зохицуулалтын талаар авах арга хэмжээний тухай
9	Тэмдэглэл-09	2017.06.30	Ай-Пи-ТВ (IPTV) үйлчилгээний талаар чиглэл өгөх тухай
10	Тэмдэглэл-10	2017.07.28	Өргөн нэвтрүүлгийн зохицуулалтын талаар авах арга хэмжээний тухай
11	Тэмдэглэл-11	2017.07.28	Тусгай зөвшөөрлийг дуусгавар болгох тухай (22 иргэн, хуулийн этгээд)
12	Тэмдэглэл-12	2017.08.30	Он-лайн контентийн зохицуулалтын баримт бичиг боловсруулах чиглэлийн тухай
13	Тэмдэглэл-13	2017.08.30	Зөвлөх үйлчилгээний төслийн явц, тайлангийн тухай
14	Тэмдэглэл-14	2017.09.28	Аргачлалын баримт бичгийн талаар авах арга хэмжээний тухай
15	Тэмдэглэл-15	2017.10.27	Өргөн нэвтрүүлгийн зохицуулалтын талаар баримтлах чиглэл, удирдамжийн тухай
16	Тэмдэглэл-16	2017.10.27	Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх болон хөтөлбөрт баримтлах зөвлөмжийн тухай
17	Тэмдэглэл-17	2017.10.27	Тоон контентын зохицуулалтын талаар удирдамж, чиглэл өгөх тухай
18	Тэмдэглэл-18	2017.11.30	“Харилцаа холбооны зохицуулах хорооны 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт, төсвийн гүйцэтгэл”-ийн тухай
19	Тэмдэглэл-19	2017.11.30	“Харилцаа холбооны зохицуулах хорооны 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөө болон төсвийн төсөл”-ийн талаар авах арга хэмжээний тухай
20	Тэмдэглэл-20	2017.11.30	Зохицуулалтын үйлчилгээний хэмжээний талаар цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний тухай